



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.06.17 № 03/1225

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зарласан НХААГ/20240103245/03/01 дугаартай тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгад захиалагчаас өгсөн хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	<p>Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-н 4 а) “Тендер шалгаруулалтад санал болгосон инженер техникийн ажилтан, машин механизмуудын 30-аас дээшгүй хувийг өөр ижил төстэй ачаа тээврийн ажилд давхардуулан санал болгож болно. Давхардуулан санал болгосон ачаа тээврийн ажил нь 70 хувиас бага гүйцэтгэлтэй тохиолдолд тендерээс татгалзана” гэсэн байна. Иймд дараах 2 зүйлийг тодруулж өгнө үү.</p> <p>1.Инженер техникийн ажилтан гэдэгт ямар ямар албан тушаалтныг хамруулж байгаа вэ? Нягтлан, механик инженер, ХАБЭА-н ажилтан, диспетчер, жолооч, ачигч нар бүгд хамаарах уу?</p> <p>2.Үндсэн ажилтан буюу нягтлан, ХАБЭА-н ажилтан, диспетчер, механик инженер 4-ийг 70 хувиас бага гүйцэтгэлтэй ажилд</p>	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн 19.1</p> <p>4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”</p> <p>а)Тендер шалгаруулалтад санал болгосон инженер техникийн ажилтан, машин механизмуудын 30-аас дээшгүй хувийг өөр ижил төстэй ачаа тээврийн ажилд давхардуулан санал болгож болно. Давхардуулан санал болгосон ачаа тээврийн ажил нь 70 хувиас бага гүйцэтгэлтэй тохиолдолд тендерээс татгалзана.</p> <p>Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн 19.2 Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <p>4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг нотлох баримт бичиг;</p> <p>Одоо хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл байгаа бол Маягт 4 маягтаар гаргаж, тайлбар болон ажлын гүйцэтгэлийн талаарх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>а)Тендерт оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж</p>

<p>давхардуулан санал болгосон боловч жолооч ачигч нарыг зөвхөн тухайн ажилд санал болгож байгаа тохиолдолд тендерийн шалгуурыг хангасан тооцох уу.</p>	<p>байгаа, хэрэгжүүлэх эрх авсан ажлын гүйцэтгэлийн явцын талаарх мэдээллийг тус тус ирүүлнэ.</p> <p>-Захиалагч ажлын гүйцэтгэлийн явц, ажилтан, машин механизмын талаар мэдээллийг холбогдох байгууллагын мэдээллийг сангаас хянан үзнэ.</p>
---	---